



## ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ Х ЦАХИМ ӨГӨГДЛИЙН ХАЙРЦАГ

**ХАЙРЦАГ (SCHRÁNKA)** нь хүргэсэн захидлыг хадгалах газар юм.

- Шуудангийн хайрцгийн хувьд энэ нь хэвлэсэн болон гараар бичсэн захидал юм.
- Цахим өгөгдлийн хайрцгийн хувьд энэ нь цахим хэлбэрээр бичигдсэн захидал юм.

### ОРШИН СУУЖ БУЙ ЗӨВ ХАЯГИЙГ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДАД БҮРТГҮҮЛСЭН БАЙХ НЬ ЧУХАЛ.

Байнгын оршин суух газар - нь зөвхөн нэг байх ба энэ нь жинхэнэ оршин суугаа газартай ижил байх албагүй. Энэ тохиолдолд захидал харилцааны хаягийг (эсвэл хүргэх хаяг) эрх бүх байгууллагад мэдээлэх нь чухал юм.

**ОРШИН СУУГАА ХАЯГИЙНХАА ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ БОЛОН ХОНХ НЬ ДЭЭР БҮТЭН НЭР ОВГОО ТЭМДЭГЛЭСЭН БАЙХ ХЭРЭГТЭЙ.** Нэг өрхөд өөр өөр овогтой хэд хэдэн хүн амьдарч байгаа тохиолдолд шуудангийн хайрцаг, хаалганы хонх дээр нэг өрхийн хүмүүсийн нэр, овгийг бүгдийг нь бичих шаардлагатай.

**ЯАГААД ХАЙРЦГАА ТЭМДЭГЛЭЖ, ШУУДАНГАА ХҮЛЭЭН АВАХ НЬ ЧУХАЛ ВЭ?** Захидлыг гараар хүргэх үед та биеэр аваагүй байсан ч илгээмжийг хүргэсэн гэж үзэх дараах хоёр нөхцөл байдал үүсэж болно:

**1. Та өөрийн овог нэрээр зохих ёсоор тэмдэглэгдсэн шуудангийн хайрцагтай боловч шууданч гэрт тань хүргэх боломжгүй бол - захидал шуудангийн газарт хадгалагдана:**

- Захидал/илгээмж хадгалсан тухай мэдээллийг "хүлээн авах дуудлага" гэж нэрлэдэг ба шуудангийн хайрцагт эсвэл өөр тохиромжтой газар хадгалагдсан байна.
- Заримдаа шуудангийн хайрцагт "хүлээн авах дуудлага" ирэхгүй байх боломжтой. Хэрэв та албан бичиг хүлээж байгаа бол танд хүргэгдээгүй эсэхийг холбогдох шуудангийн салбараас шалгахыг зөвлөж байна.
- Та хүлээн авах дуудлагад 10 хоногийн дотор хариу өгөх ёстой (захиагаа шуудангийн газраас авах). Хадгалснаас хойших арав дахь өдөр (хадгалах өдрийг 0 өдөр гэж тооцно), ямар нэгэн шалтгаанаар захиагаа аваагүй ч ("хүлээн авах дуудлагыг" хүлээн аваагүй байсан ч) ачааг хүргэсэн гэж үзнэ (үүнийг зохиомол хүргэлт гэж нэрлэгддэг). Захидлыг хүлээн авсанд тооцогдох бөгөөд буцах аргагүй болно.

**2. Та шуудангийн хайрцаг мөн хонхоо тэмдэглэгээгүй ба шууданч гэрт тань хүргэх боломжгүй, түүнд "хүлээн авах дуудлага" хийх өөр тохиромжтой газар байхгүй бол та ямар ч мэдэгдэл хүлээн авахгүй - захидал илгээгчид буцаах бөгөөд тэр (хэрэв энэ нь эрх бүхий албан газар бол) түүнийг нийтийн зар мэдээллээр дамжуулна:**


- Захидал, захидал хүлээн авах боломжтой тухай мэдэгдлийг албан ёсны самбар болон цахим албан ёсны самбарт байрлуулна. Илгээсэн огноог захидал дээр тэмдэглэсэн байна.
- ОАМР-ын албан ёсны самбар нь дараах хаягаар орох боломжтой:  
<https://www.mvcr.cz/verejne-vyhlasaky-oamp.aspx>.
- Захидал агуулгатай нь танилцсан эсэхээс үл хамааран түүнийг нийтэлсэн өдрөөс хойш арван тав дахь өдөр (нийтэлсэн өдрийг 0 өдөр гэж тооцно) хүргүүлсэн гэж үзнэ.

**! АНХААР ! 2 ТОХИОЛДОЛД ХОЛБОГДОХ ГАЗРААС ТА ЗАХИДЛАА АВААГҮЙ БОЛ ЧУХАЛ ХУГАЦАА АЛДАЖ БОЛНО, жишээлбэл дутуу бичиг баримтыг нэмэх гм. Та өөрөө ч мэдэлгүй хугацаа нь дуусна! Энэ нь таны өргөдлийг хүлээн авахаас татгалзах эсвэл түдгэлзүүлэх шалтгаан байж болно. Үүний үр дагавар нь та Чех улсад оршин суух эрхээ алдах/дуусгавар болох боломжтой юм.**

**Хэрэв та хаяг, хайрцаг дээрээ тэмдэггүй бол эсвэл шуудан хүргэхэд асуудал гарвал, бид цахим өгөгдлийн хайрцагтай болхийг зөвлөж байна. ЦАХИМ ӨГӨГДЛИЙН ХАЙРЦАГ (DATOVÁ SCHRÁNKA) нь шуудангийн хайрцгийн цахим хэлбэр (энэ нь цахим шуудан биш) бөгөөд үүгээр дамжуулан та бүх эрх бүхий байгууллага, захиргааны байгууллагатай харилцах боломжтой.**



FINANCOVÁNO  
EVROPSKOU UNÍÍ  
AZYLOVÝ, MIGRAČNÍ  
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Poradna  
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financováno Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.